



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/428

Улаанбаатар хот

### Г Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 23 дугаар зүйлийн 23.1.3, 23.1.4, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтооолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 15.3, 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх "хяналтын хуудас"-ыг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч наарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын өрөнхий газрын дарын  
2024 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн  
2 дугаар тушаалын хавсралт



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС,  
ТЭСЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АЖ  
АХУИН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН  
ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

**1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

|  |  |   |  |
|--|--|---|--|
| Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:                                   |  |   |  |
| Шалгуулагч хуулийн этгээдийн нэр:                                    |  |   |  |
| Регистрийн дугаар:   |  |   |  |
| Объектын нэр, хаяг, солбицол:  |  |   |  |
| Байгуулагдсан огноо:   |  |   |  |
| Үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо:                                |  |   |  |
| Дарга, захирал (иргэн, эрхлэгч)-ийн нэр, холбоо барих утасны дугаар: |  |   |  |
| Хяналт шалгалт хийсэн огноо:   | Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн огноо: | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо: |  |
| Шаардлага хангасан шалгуур үзүүлэлтийн тоо:                          | /...../...../  | /...../...../                             |  |
| Шаардлага хангаагүй нийт оноо:                                       | /...../...../  | /...../...../                             |  |
| Хууль сахин мөрдөлтийн хувь:   | /...../...../  | /...../...../                             |  |
| Эрсдэл үүсэх магадлалын хувь:  | /...../...../  | /...../...../                             |  |
| Эрсдэл үүсэх магадлал:   | / их, дунд, бага /   | / их, дунд, бага /                        |  |

**2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ:**

| № | Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт   | Шалгуур үзүүлэлт   | Батлагдсан оноо    |                     | Авсан оноо | Гүйцэтгэлийн хяналт шалгалт |
|---|---|--|--------------------|---------------------|------------|-----------------------------|
|   |   |  | Шаардлага хангасан | Шаардлага хангаагүй |            |                             |
| 1 | 2   | 3  | 4                  | 5                   | 6          | 7                           |
| 1 | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт   | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн Улсын бүртгэлийн гэрчилгээ (хуулбар)      | 0                  | 4                   |            |                             |
| 2 | Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт  | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл (хуулбар)                            | 0                  | 4                   |            |                             |
| 3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.6, 9 дүгээр зүйлийн 9.1.3, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан эсэх, | 0                  | 4                   |            |                             |

| 1  | 2   | 3   | 4 | 5 | 6 | 7 |
|----|---|---|---|---|---|---|
| 4  | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6 дахь заалт  | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд байгаль орчинд нэлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн эсэх?   | 0 | 4 |   |   |
| 5  | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 10.7, 12 дугаар зүйлийн 12.1, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6 дахь заалт   | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх?  | 0 | 4 |   |   |
| 6  | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.   | Галын аюулгүй байдлын дүгнэлт байгаа эсэх?  | 0 | 4 |   |   |
| 7  | 19.2, Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 1 дэх заалт  | Үйлдвэр, агуулахын галын булан байгаа эсэх?   | 0 | 4 |   |   |
| 8  | Зөрчлийн тухай хуулийн 5.12 зүйлийн 2.3, 5.13 дугаар зүйлийн 5, Газрын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт   | Газар эзэмших эрхийн гэрчилгээ байгаа эсэх?   | 0 | 4 |   |   |
| 9  | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 12 дугаар зүйлийн 12.1.3, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 9, 16, 17 дахь заалтууд | Мэргэжлийн ажиллах хүчинээр /удирдагч, тэсэлгэчин, тэсрэх материалын агуулахын эрхлэгч, нярав, цэнэглэгч машины оператор, тэсрэх материалтай харьцах ажилтан, тээврийн хэрэгслийн жолооч/хангагдсан эсэх                  | 0 | 4 |   |   |
| 10 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт  | Өөрийн эзэмшилийн газар дээр байгуулсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байнгын агуулах, ачиж буулгах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй эсэх? | 0 | 4 |   |   |

| 1  | 2  | 3  | 4 | 5 | 6 | 7 |
|----|--|--|---|---|---|---|
| 11 | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 181 дүгээр заалт              | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж баталгаажуулсан эсэх?   | 0 | 4 |   |   |
| 12 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалт | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн мэдээ (Тусгай зөвшөөрлийн хурээнд он тус бүрээр)   | 0 | 4 |   |   |
| 13 | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 18 дахь заалт                 | Тэсэлгээний ажлын паспортууд байгаа эсэх?  | 0 | 4 |   |   |
| 14 | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 605 дахь заалт                | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн шаардах хуудас байгаа эсэх?  | 0 | 4 |   |   |
| 15 | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 597, 598, 599 дэх заалт       | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын бүртгэлийн дэвтэр байгаа эсэх?  | 0 | 4 |   |   |
| 16 | Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2023 оны А/107 дугаар тушаал  | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын батлагдсан зураг тесел   | 0 | 4 |   |   |
| 17 |  | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын аюулгүйн бүс тогтоосон акт, ашиглалтын дүгнэлт   | 0 | 4 |   |   |
| 18 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 дахь заалт                   | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж байгууллагад газар өгөхгүй байх | 0 | 4 |   |   |

| 1         | 2  | 3  | 4 | 5   | 6 | 7 |
|-----------|--|--|---|-----|---|---|
| 19        | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт                     | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тусгай тоноглосон тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа эсэх?   | 0 | 4   |   |   |
| 20        | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт                     | Үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу заавал даатгуулсан эсэх?                         | 0 | 4   |   |   |
| 21        | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтооюур батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 175 дахь заалт           | Тэсрэх материалтай харьцахдаа тэдгээрийг хэрэглэх заавар, аюулгүй ажиллагаа, галын аюулгүйн зааврыг дагаж мөрддөг эсэх? Заавар, журамтай эсэх?   | 0 | 4   |   |   |
| 22        | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтооюур батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 175 дахь заалт           | Тэсрэх материалтай харьцах ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, ажилчдыг тэсрэх бодисын тоос, тэсрэлтээс үүссэн хорт хийнээс хордохос урьдчилан сэргийлэх арга хэмжээний баримт бичгийг баталж, мөрддөг эсэх? | 0 | 4   |   |   |
| 23        | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтооюур батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 196, 197 дахь заалт      | Тэсэлгээний ажлын үед дуут дохио ашигладаг эсэх?   | 0 | 4   |   |   |
| 24        | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтооюур батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 665, 666, 667 дахь заалт | Тэсрэх бодисын үйлдвэрийн технологийн процессын удирдамж, хяналтын удирдамжтай эсэх?   | 0 | 4   |   |   |
| 25        | Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтооюур батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 690 дэх заалт            | Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч цахилгаан статик цэнэг үүсэх аюулаас сэргийлэх арга хэмжээ авсан эсэх?   | 0 | 4   |   |   |
| Нийт оноо |  |  | 0 | 100 |   |   |

Шаардлага хангаагүй нийт оноо:

>=50% Их эрсдэлтэй

[30%-49%] Дунд эрсдэлтэй

<=29% Бага эрсдэлтэй

### 3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

|   |  |   |
|---|--|---|
| Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг | Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг |
| / албан тушаал /  | / албан тушаал /   | / албан тушаал /  |
| / овог, нэр /   | / овог, нэр /  | / овог, нэр /   |
| / гарын үсэг, тэмдэг /                                  | / гарын үсэг, тэмдэг /   | / гарын үсэг, тэмдэг /  |

### ТАЙЛБАР:

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР